



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 22 өдөр

Дугаар А/26

Хэрлэн сум

Хүндэтгэл үзүүлэхэд,  
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалт, аймгийн Засаг даргын 2015 оны А/562 дугаар захирамжаар баталсан "Оны шилдэг ажилтан, байгууллага" шалгаруулах журмыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн оны шилдэг ажилтан, байгууллагын шагналд 2,230,000 (хоёр сая хоёр зуун гучин мянган) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Дээрх арга хэмжээний зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн шагнал урамшууллын зардлаас олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2024  
оны 01 дүгээр сарын 22-ны  
... дугаар захирамжийн хавсралт

Зардалын тооцоо

Д/д	Зардлын нэр	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Оны шилдэг байгууллагын шагнал	2	1,000,000	2,000,000
2	Оны шилдэг байгууллагын өргөмжлөл	2	85,000	170,000
3	Батламж	4	15,000	60,000
Нийт				2,230,000